

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Хөвсгөл аймгийн эдийн засаг нийгмийг 2008-2015 онд хөгжүүлэх хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний биелэлт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ нэр, байршил, хүчин чадлаар	Эхлэх дуусах хугацаа	2009 оны зорилтын биелэлт	Тухайн жилийн зорилтын биелэлтийн хувь	2015 оны зорилтын биелэлтийн хувь
1	2	3	4	5	6
Нэг.Хүний болон нийгмийн хөгжлийн хүрээнд:					
а/.Боловсрол, соёлын салбарт:					
1	Хүүхэд, хөгжил залуучуудын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	2009-2015	2010 онд хүүхэд хөгжил хөтөлбөр боловсруулахаар төлөвлөсөн.	Хугацаа болоогүй	
2	Хүүхдийн ордон барьж ашиглалтанд оруулах	2009-2011	Зураг, төсвийг бэлэн болгож, хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлсэн.	100	30
3	ЕБС-ийн дунд сургуулийн 10 хичээлийн байр шинээр барьж, 23 хичээлийн байрыг засварлаж өргөтгөх	2009-2015	Цэцэрлэг, Тариалан, Мөрөн, Ханх, Цагааннуур сумд, Хатгал тосгонд хичээлийн шинээр ашиглалтад оруулж, Арбулаг сумын хичээлийн байранд өргөтгөл хийж, Галт, Жаргалант сумдад хичээлийн байр шинээр эхэлж, Арбулаг, Төмөрбулаг, Бүрэнтогтох, Улаан-Уул, Чандмань-Өндөр сумд, Бүрэнхаан багийн бага сургуулийн хичээлийн байрны их засвар хийсэн.	100	70
4	7 сургуулийн дотуур байр шинээр барьж, 20 дотуур байрыг өргөтгөж, засвар хийх	2009-2015	Баянзүрх, Ренчинлхүмбэ сум дад дотуур байр шинээр барьж ашиглалтад оруулж, Бүрэнтогтох, Цэцэрлэг сумдын хичээлийн байрыг засварлав.	100	50

1	2	3	4	5	6
5	Бүх суманд электрон номын сан бий болгох	2009-2015	Чандмань-Өндөр суманд интернет номын сан ашиглалтад оруулж, Аймгийн Нэгдсэн номын сангийн барилгыг ашиглалтад интернет номын сан байгуулах боломжийг бүрдүүлсэн.	100	30
6	ЕБС-уудыг сургалтын материал, тоног төхөөрөмжөөр хангах	2009-2015	Алаг-Эрдэнэ сумын ЕБС-д бялдаржуулах танхим, Алаг-Эрдэнэ, Арбулаг сумын сургуульд технологийн хичээлийн тоног төхөөрөмжөөр хангаж, Тосонцэнгэл, Мөрөн сумын ДЦС-ийг сургалтын тоног төхөөрөмжөөр хангаж, Тариалан суманд сурагчдын хөгжлийн төв ашиглалтанд оруулав.	100	50
7	4 сумын СӨБ-ын барилга шинээр барьж, 23 барилгад их засвар өргөтгөл хийх	2009-2015	Мөрөн суманд 100, 150 ортой цэцэрлэг барьж, II цэцэрлэг, Түнэл сумын цэцэрлэгийн барилгыг өргөтгөж, Цагааннуур, Цагаан-Үүр сумдын цэцэрлэгийн барилга, Мөрөн сумын YII цэцэрлэгийн сантехникийн засвар хийв.	100	50
8	СӨБ-ын тоглоом наадгайг шинэчлэн сургалтын орчинг сайжруулах	2009-2015	Улаан-уул суманд Бүжинхэн цэцэрлэг байгуулж, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Эрдэнэбулган сумдын цэцэрлэгийг тоглоом, наадгайгаар хангаж, Мөрөн сумын 5 дугаар цэцэрлэгийн урлагийн танхим, Цэнхэр дэлхий цэцэрлэгийг тохижуулж, техник хэрэгслэлээр хангав.	100	50

1	2	3	4	5	6
9	3 суманд соёлын төвийн барилга шинээр барьж, 18 сумын соёлын төв засварлаж, шинэчлэх	2009-2015	Улаан-Уул сумын соёлын төвийн барилга шинээр барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, гүйцэтгэгчийг сонгож, Цагааннуур сумын соёлын төвийн барилга, Ренчинлхүмбэ сумын дээврийг засварлаж, Цэцэрлэг сумын соёлын төвийг тохижуулсан.	100	30
10	Бүх сумын соёлын төвийг техник хэрэгслэлээр хангаж, материаллаг баазыг бэхжүүлэх	2009-2015	Жаргалант, Тариалан, Галт, Шинэ-идэр, Эрдэнэбулган сумдын соёлын төвд хөгжим, техник хэрэгслэлээр хангаад байна.	100	30
Боловсрол, соёлын салбарын дүн					
б/.Эрүүл мэндийн салбарт:					
1	7 сумын хүн эмнэлгийн барилга шинээр барьж, 14 сумын хүн эмнэлгийн барилгыг засаж, өргөтгөх	2009-2015	Арбулаг сумын хүн эмнэлгийн сантехникийн засвар, Арбулаг, Төмөрбулаг, Түнэл сумдын эхчүүдийн амрах байрыг тохижуулж, Тариалан суманд эхчүүдийн амрах байрыг ашиглалтад оруулж, Цэцэрлэгийн Могойн голын хүн эмнэлгийн халаалтын шугамын засвар хийлээ.	100	30
2	20 сумын хүн эмнэлгийг оношлогооны тоног төхөөрөмжөөр хангаж, материаллаг баазыг бэхжүүлэх	2009-2015	Их-Уул, Тосонцэнгэл, Жаргалант суманд хүн эмнэлгийн багаж төхөөрөмжөөр хангасан.	100	30
3	Бүх сумд, Нэгдсэн эмнэлэг, ЭМГ-ын түргэн тусламжийн машин шинэчлэх	2009-2015	Их-Уул, Улаан-Уул, Цэцэрлэг, Ханх, Нэгдсэн эмнэлгийг түргэн тусламжийн машин олгов.	100	30
4	Бүх сумыг спортын заалтай болгож, техник хэрэгслэлээр хангах	2009-2015	Их-Уул сумын ЕБС-ийн спорт заалыг өргөтгөсөн.	100	10
5	Эрүүл мэндийн үйлчилгээнд цахим оношлогооны багаж, техник хэрэгсэл ашиглах боломж бүрдүүлэх	2009-2015	Аймгийн Нэгдсэн эмнэлэг болон бүх сумд оношлогооны багаж хэрэгслэлээр хангагдсан.	100	50

1	2	3	4	5	6
6	Бүх сумыг эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа, эрүүлжүүлэх танхимтай болгох	2009-2015	Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, сумдын бүх эмнэлэг эрүүл мэндийн сургалт сурталчилгааны танхимтай болж, 17 сумын эмнэлэг, өрхийн 6 эмнэлэг чийрэгжилтийн танхимтай болсон.	100	90
7	Багийн эмч нарыг унаажуулж, зориулалтын ажлын байртай болгох	2009-2015	Их-Уул, Арбулаг сумын 3 дугаар баг, Шинэ-Идэр, Эрдэнэбулган, Баянзүрх, Ханх сумын багийн эмчид мотоцикл, Мөрөн сумын өрхийн 6 эмнэлэгт түргэн тусламжийн машин олгов.	100	30
Хоёр.эдийн засгийн өсөлт, хөгжлийн бодлогын хүрээнд:					
а.Дэд бүтцийн салбарт:					
1	Уньт-Мөрөнгийн хатуу хучилттай 260 км зам барьж ашиглалтад оруулах	2009-2015	Уньт-Мөрөнгийн хатуу хучилттай 260 км зам барих асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж, 2010 онд ажлыг эхлүүлэх хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлсэн.	100	10
2	Мөрөн-Хатгалын хатуу хучилттай 105 км зам ашиглалтад оруулах	2009-2010	Мөрөн-Хатгалын хатуу хучилттай 98.8 км замын хөрөнгийн асуудал шийдэгдэж, ажил эхэлсэн	100	30
3	Эрдэнэт-Мөрөнгийн 420 км төмөр зам барих ажлыг эхлүүлэх	2010-2015		Хугацаа болоогүй	
4	Ханх-Хатгалын Хөвсгөл нуурын баруун талаар холбосон зам тавихад	2009-2011	Холбогдох яам тусгай газруудад асуудал тавьж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлсэн.	100	30
5	Мөрөн-Архангайн Цэцэрлэгийн авто замыг сайжруулах	2009-2011		30	10

1	2	3	4	5	6
6	Булганы Дашинчилэн-архангайн хайрхан-Өлзийт-Хөвсгөлийн Рашаант-Тосонцэнгэл-Мөрөнгийн хатуу хучилттай зам барьж ашиглалтад оруулах	2009-2012	Холбогдох яам тусгай газруудад асуудал тавьсан боловч хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй.	30	10
7	Орон нутгийн зам, даваа, гүүрийг засварлаж сайжруулах	2009-2015	Тариалангийн Далт, Шивэрт, Төмөрбулагийн Гөнтөг, Шинэ-Идэрийн Бумбат, Ханхын Хавцлын даваа, Рашаантын Царам даваа, Бүрэнтогтохын Загзуугийн боомын зам засварлаж, Бүрэнтогтох, Чандман-Өндөр, Ренчинлхүмбийн орон нутгийн зам, Галт, Алаг-Эрдэний Эгийн гол, Жаргалантын Цэцүүх, Хөнжлийн гол, Ренчинлхүмбийн Далайн хоолой, Цацадын хар уст, Баянгол, Цагааннуурын Хармайн голд гүүр барив.	100	50
8	Сэлэнгэ голын Цацын буланд төмөр бетон гүүр барих	2009-2010	Холбогдох яам, тусгай газруудад санал тавьсан боловч хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй	30	10
9	Жаргалантын Идэрийн голд төмөр бетон гүүр барих	2009-2012	Зураг, төсвийг бэлэн болгож, хөрөнгийг асуудлыг шийдвэрлэж, 2012 онд ашиглалтад оруулна.	100	30
10	15 сумын төвийн дулааны эх үүсвэрийг шинэчлэх	2009-2015	11 сумын дулааны шугамыг шинэчлэх зураг төсөв бэлэн болсон. Мөрөн сумын 440-ын зуухны өргөтгөлийн ббарилгад тогоо нэмж, 32 айлын сууцнуудын гадна инженерийн шугам сүлжээний шинэчлэлт, Тариалан сумын 200 м дулааны шугам, Их-Уул сумын 87 м шугам, халаалтын тогоог шинэчилсэн.	100	30

1	2	3	4	5	6
11	Бүх сумын төвийг шилэн кабельд холбох	2009-2010	Аймгийн 23 сум, 1 тосгон ЦДАШ-д холбогдж, бүх сумдыг шилэн кабель тавих нөхцөл бүрдсэн.	100	30
12	Бүх багийн малчдыг хөдөлгөөнт холбоогоор хангахад	2009-2010	23 сум, 1 тосгоны хөдөлгөөнт холбоогоор үйлчлүүлэх хүсэлтэй хөдөөгийн малчид хангагдсан.	100	70
б.Хөдөө аж ахуйн салбарт:					
1	Бүх суманд шинээр гүн өрмийн худаг гаргаж, засварлах	2009-2015	2009 онд Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд 5 худгийг 63.9 сая, улсын төсвийн хөрөнгөөр 8 худгийг 110,0 сая төгрөгөөр 11 суманд гаргав.	100	50
2	Сүргийн бүтцийг сайжруулж, малын үүлдэр угсааг сайжруулж, үхэр сүргийг илүү өсгөх арга хэмжээ авах	2009-2015	Үхэр сүргийг илүү хөгжүүлэх зорилгоор 2010 онд Үхэр өсгөх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээд аймгийн эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаж, 2009 онд шилмэл малын үзэсгэлэн гаргаж, урамшуулаад байна.	100	10
3	Фермерийн загвар аж ахуйг хөгжүүлэх арга авах	2009-2015	Аймгийн төвийн ойролцоо мах сүүний чиглэлийн фермерийн аж ахуй байгуулах 3 төсөл боловсрогдон сонгон шалгаруулах шатандаа явж байна.	100	10

1	2	3	4	5	6
4	Атрын III аяныг хэрэгжүүлж, газар тариалангийн үйлдвэрлэлийг өргөтгөх, техник тоног төхөөрөмжинд шинэчлэлт хийх	2009-2015	Атрын таяныг хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлснээр дотоодын үйлдвэрлэлийн улаанбуудай, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл өмнөх жилийнхээс 37,2 хувиар нэмэгдэж, аймгийн хэрэгцээт гурилыг 100, төмс 46,0, хүнсний ногооны 12,8 хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангах боломж бүрдэв.	100	70
Гурав.Байгаль орчны бодлого хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд:					
1	Байгалийн эрдэс баялаг нөөцийг бүрэн судалгаанд хамруулж, аймгийн газар нутгийн 1:50000 масштабын зураглал хийлгэх	2009-2015	Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүсэлт тавьсан.	10	10
2	Аймгийн ой зохион байгуулалтыг хийх	2009-2010	12 сумын 43 нөхөрлөлийн 135466 га-д ой зохион байгуулалт хийсэн. Аймгийн ой зохион байгуулалтыг 2012 онд хийхээр төлөвлөж байна.	100	50
3	7000 га талбайг ойжуулахад	2009-2015	327 га талбайд ойжуулалт, 100 га-д байгалийн сэргэн ургалтад туслах ажил хийв.	100	30
4	Усны эх үүсвэр, булаг шандны эхийг хамгаалах арга хэмжээ авах	2009-2015	20 сумын 22 рашаан булгыг тохижуулахад 30,0 гаруй сая төгрөг зарцуулав.	100	50
5	Цөлжилтөөс хамгаалж, төв суурингийн 1800 га талбайг моджуулж, цэцэрлэгжүүлэх	2009-2011	Жаргалант, Их-Уул, Ренчинлхүмбэ суманд цөлжилт, элсний нүүдэл хамгаалах зурвас 13 га-д байгуулж, бүх нийтээр моджуулах хөдөлгөөн өрнүүлж, 14 төрлийн 19400 ш мод тарьж, 9 ш цэцэгийн мандал, 2000 м саад байгуулж, 20,0 сая төгрөг зарцуулж байна.	100	30

1	2	3	4	5	6
6	Ховор ховордсон ан амьтан, ургамлын тооллого явуулж, устахаас урьдчилан сэргийлж нөхөн сэргээх арга хэмжээ авах	2009-2015	Ховор амьтан болох Тул хамгаалах аймгийн дэд хөтөлбөр боловсруулан Хорьдол Сарьдагийн Дархан цаазат газрын хүдэр, аргал угалзны тооллого хийсэн.	100	30
7	Хог хаягдлыг ангилан боловсруулах төсөл боловсруулж хэрэгжүүлэх	2009-2011	Мөрөн суманд Ландфилийн аргыг хэрэглэж, хог хаягдлыг эмнэлэг, барилгын материал, аюултай, бусад гэсэн ангилалаар ялгаж, усгаж, хэрэглэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд 50,0 сая төгрөг зарцуулав.	100	30
Дөрөв.Хууль, эрх зүй, төрийн байгуулалтын хөгжлийн бодлогын хүрээнд:					
1	5 сумын ЗДТГ-ын барилгыг шинээр барьж, 14 сумын ЗДТГ-ын барилгын засвар өргөтгөл хийх	2009-2012	Ренчинлхүмбэ сумын ЗДТГ-ын барилгыг шинээр ашиглалтад оруулж, Шинэ-Идэр, Цагаан-Үүр, Тариалан сумдын ЗДТГ-ын барилга барьж байна.	90	30
2	Сумын ЗДТГ-ыг техник хэрэгслэлээр хангаж, нэгдсэн мэдээллийн сүлжээнд оруулах	2009-2010	23 сум, 1 тосгоныг интернет мэдээллийн төвтэй болгох санал тавьж, хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлээд байна.	100	30
3	Сумдын ЗДТГ-ын суудлын автомашиныг шинэчлэх	2009-2015	Мөрөн сумын болон аймгийн Засаг даргын суудлын авто машиныг шинэчлэв.	100	30
4	Багийн төвийг тохижуулж, байнгын ажиллагаатай болгох	2009-2010	Багийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж,	100	30
5	Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн хэмжих хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжөөр хангах	2009-2010	МХГ-ын лабораторид 22 нэр төрлийн 40,0 гаруй сая төгрөгийн хэмжих хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж авч бүх төрлийн шинжилгээг орон нутагтаа хийх боломжтой болсон.	100	100

1	2	3	4	5	6
6	Архивын зориулалтын барилга барьж ашиглалтад оруулах	2009-2010	Архивын зориулалтын байр бариулахаар холбогдох байгууллагуудад хүсэлт тавьсан	30	10
7	Аймаг, сумдын эрх зүйн мэдээллийн кабинет байгуулж тохижуулах	2009	Аймгийн ЗДТГ-т Эрх зүйн мэдээллийн төв байгуулан хууль эрх зүйн зөвлөгөө өгөх ажилтан, эмзэг бүлгийн иргэдэд үйлчилгээ үзүүлэх орон тооны өмгөөлөгч ажиллаж, техник хэрэгслэлээр хангасны гадна Тариалан, Шинэ-Идэр сумдад эрх зүйн мэдээллийн кабинет ажиллуулж, аймгийн хэмжээгээр 12677 иргэнд эрх зүйн зөвлөгөө өгсөн байна.	100	70
8	Хөдөөгийн баг хөгжүүлэх арга хэмжээ авах	2009-2015	Хөвсгөл аймгийн Багийн хөгжлийг хангах дэд хөтөлбөр батлан мөрдөж, баг хөгжүүлэх арга хэмжээнд 2010 онд 350,0 сая төгрөг зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлсэн.	100	50
9	121 багийг мэдээллийн цахим сүлжээнд холбох	2010-2010		Хугацаа болоогүй	
10	21 суманд Цагдаагийн кабон барих	2010-2012	Холбогдох байгууллагуудад хүсэлт тавьсан.	30	10
11	Эрсдэлийн сан бүрдүүлэх	2009-2012	Сан бүрдээгүй.		
Мөрөн сумыг загвар хот болгох					
1	Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, экологийн карт боловсруулж мөрдөх	2009-2010	Мөрөн сумын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэхээр 2010 онд 50,0 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, холбогдох судалгааны ажил хийж байна.	100	70

1	2	3	4	5	6
2	2 сургууль шинээр барьж, 5 сургуулийн хичээлийн байрыг засварлах	2009-2015	7 дугаар багт Бага сургууль барьж ашиглалтанд оруулж, 928 суудалтай хичээлийн байр барьж эхлэн ДЦС-ын барилгыг засварлах зураг төсвийг бэлэн болгож, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх бэлтгэл ажлыг гүйцэтгэж байна.	100	30
3	3 СӨБ-ийн барилга шинээр барьж 9 СӨБ-ын барилгыг засаж сайжруулах	2009-2015	Мөрөн суманд 150, 100 ортой цэцэрлэгийн барилга ашиглалтанд оруулж, II цэцэрлэгийн барилгыг өргөтгөж, Y, YII цэцэрлэгийн барилгыг засварлаж, 2010 онд I, III цэцэрлэгийн барилгыг засварлах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн.	100	50
4	МСҮТ шинээр байгуулах	2009-2015	Уул, уурхай, хөдөө аж ахуйн чиглэлийн МСҮТ-ийн байгуулах санал боловсруулж, холбогдох дээд байгууллагуудад санал тавиад байна.	100	10
5	Сумын дотор 10 км хатуу хучилттай зам барьж, замын тэмдэг байрлуулах	2009-2015	2009 онд 2 км хатуу хучилттай зам барьж, 2010 онд хатуу хучилттай зам тавьж, хуучин замыг шинэчлэхээр 500,0 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэв.	100	70
6	Явган хүний замыг бүх замын дагуу тавьж, замын тэмдэгжүүлэх	2009-2010	1000 м газарт 10,0 сая төгрөгийн явган хүний зам тавив.	100	50
7	Төвийн баруун зах-Нисэх хүртэл гэрэлтүүлэг тавих	2009-2010	Холбогдох байгууллагуудад хүсэлт тавьсан.	30	10

1	2	3	4	5	6
8	Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авах	2009-2010	Агаарын бохирдлыг бууруулах явуулын харуулын албыг МТ шатахуун түгээх байранд байрлуулж, холбогдох техник хэрэгслэлээр ханган үйл ажиллагаа явуулж байна.	100	70
9	Ногоон байгууламж барьж цэцэрлэгжүүлж тохижуулах	2009-2015	Төв замын дагуу 1750 хайс барьж, мод тарьж, 286 м2 талбайг зүлэгжүүлэн ногоон байгууламж бий болгов.	100	30
10	11 багийн засаг даргын ажлын байр шинээр барих	2009-2015	5,6 дугаар багийн конторын барилгыг бохирын системд холбох талаар холбох, багийн дарга нарын ажлын байр барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох дээд байгууллагуудад хүсэлт тавиад байна.	30	10
11	Захуудыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн байршуулж тохижуулах арга хэмжээ авах	2009-2015	"Хүнсний баталгаат байдал" аймгийн дэд хөтөлбөр боловсруулан аймгийн ИТХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор холбогдох заалт оруулан батлуулан мөрдөж ажиллаж байна.	30	10
12	Үерийн хамгаалалт барих	2009-2010	Тооцоо үндэслэл, холбогдох санал боловсруулж, яам тусгай газруудад хүргүүлсэн.	30	10

1	2	3	4	5	6
13	Инженерийн шугам сүлжээг шинэчилж засварлах	2009-2012	Мөрөн, тариалан, Их-Уул, тариалан сумдын дулааны шугам сүлжээг шинэчлэх арга хэмжээ авч Мөрөн сумын 32 айлын сууцнуудын гадна инженерийн шугам сүлжээний шинэчлэлт, Тариалан сумын 200 м дулааны шугам, Их-Уул сумын 87 м шугам шинэчилэв.	100	50
Аймгийн дүн				90	30

Тайлбар: Хөвсгөл аймгийн эдийн засаг, нийгмийг 2008-2015 онд хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөрийг Монгол улсын мянганы хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аймаг, орон нутагт хэрэгжүүлэх зорилт үзүүлэлтийг тодорхойлон оруулж, аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж мөрдөж байгаа тул, аймгийн холбогдох зорилтын биелэлтийг нэг бүрчлэн тооцож гаргав.

Хэрэгжилтийг тооцсон:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Хянасан:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА